

“БАЯН МОГУЛ” ХХК

**“АВДРАНТЫН ЦАГААН ТУГАЛГАНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(MV-020997)**



ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
ХАМРАХ ХҮРЭЭ	3
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
1.1. Төслийн нэр	7
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн мэдээлэл	7
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлантай холбоотой мэдээлэл.....	7
1.3. Орд ашиглалтын систем	8
Ил уурхайн үндсэн хэмжээ.....	9
1.3.1. Угаан баяжуулах технологи	9
1.3.2. Уурхайн ажиллах горим, хүчин чадал.....	10
1.4. Дэд бүтэц.....	10
❖ Ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ.....	11
❖ Ногоон байгууламжийн усалгаа.	11
❖ Зам талбайн усалгаа	11
❖ Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны хэмжээ	12
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ.....	12
2.1. Физик газарзүй, ландшафт.....	12
2.2. Ус зүй	13
2.3. Цаг уур.....	13
2.4. Ордын геологийн тогтоц.....	13
2.5. Ордын гидрогеологийн нөхцөл.....	14
2.6. Ургамал амьтны аймаг.....	15
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..	16
3.1. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөлөл	16
Тоосны бохирдол.....	16
Хорт хийн бохирдол.....	16
3.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл.....	16
Газрын эвдрэл.....	16
3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	16
3.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл	16
3.5. Газрын гадарга болон гүний усанд учруулах сөрөг нөлөөлөл.....	16
3.6. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал орчны эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх.	17
3.7. Нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөлөл	17
ДӨРӨВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
4.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	27
4.3. Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	30

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	31
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	31
4.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	31
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	34
ТАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	35
ЗУРГАА. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	38
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол.....	7
Хүснэгт 3. Ашиглалтын системийн үндсэн технологийн процессууд.....	9
Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд	9
Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэрийн усны тооцоо	9
Хүснэгт 6. Уурхайн ажиллах горим	10
Хүснэгт 7. Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд	10
Хүснэгт 8. Унд ахуйн зүриулалтаар ашиглах усны тооцоо.	11
Хүснэгт 9. Ногоон байгууламжын усалгаанд ашиглах усны хэмжээ.....	11
Хүснэгт 10. Зам талбай услах усны хэмжээ, м3	11
Хүснэгт 11. Элс угаан баяжуулахад ашиглах усны хэмжээ, м3	12
Хүснэгт 12. Ургамлын зүйлийн жагсаалт	15
Хүснэгт 13. Үүсэх хог хаягдлын төрөл	17
Хүснэгт 14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	18
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг	8
Зураг 2. 2024 онд техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн талбайн зураг.....	28

ОРШИЛ

Манай “Баян могул” ХХК нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших MV-020997 тоот тусгай зөвшөөрөл бүхий Авдрант нэртэй цагаан тугалганы ордыг “Пиринципал Инвестмэнтс” ХХК-аас 2024 оны 09-р сарын 02-ний өдөр албан ёсоор шилжүүлэн авч эзэмшдэг болсон.

“Авдрантын цагаан тугалганы ордыг ашиглах” төслийн БОННУ-ний тайлан нь 2022 онд батлагдсан бөгөөд байгаль орчны үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй “Байгаль тандалт” ХХК хийж гүйцэтгэсэн.

Тухайн төслийн 2025 оны БОМТ-г боловсруулахдаа Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 06-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, төслийн БОННУ зэрэг эрхзүйн баримтуудыг баримталж гүйцэтгэв.

Тус тайлангийн агуулга бүтцийн хувьд:

- Тухайн төслийн ерөнхий мэдээлэл, үйл ажиллагааны танилцуулга,
- Төсөл хэрэгжүүлэх бүс нутгийн байгаль орчны төлөв байдлын хураангуй,
- Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэсэн агуулгаар боловсруулав.

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах үйлдвэр, үйлчилгээний аливаа төсөл нь байгаль орчны хуулиудаар тогтоосон хэм хэмжээ ба төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан стандарт, нормын шаардлагад нийцүүлэн хэрэгжих ёстой.

“Авдрантын цагаан тугалганы ордыг ашиглах” төсөл нь дараах байгаль орчны хуулиуд, агаар, ус, хөрсний чанарын стандартуудыг дагаж мөрдөнө.

ХАМРАХ ХҮРЭЭ

Хуулийн заалт	Зүйл
Монгол улсын үндсэн хуулиас	
1. Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.	Монгол Улсын Үндсэн Хууль Зургаадугаар зүйл
2. Монгол улсад иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.	
3. Төр газрын эзэд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлыг ашиг сонирхолд харшаар ашиглавал хурдан авч болно.	
4. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.	Арвандолдугаар зүйл
Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас	
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараах үүрэгтэй. 1. Хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях.	Тавдугаар бүлэг Хориннэгдүгээр зүйл Байгаль орчныг бохирдохоос хамгаалах
Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна.	Гучиннэгдүгээр зүйл

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх; 2. Бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх; 3. Өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх.	Аж ахуйн нэгж байгууллагын үүрэг
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиас Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна; Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага батална.	
Агаарын тухай хуулиас	
9.1.1 Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах 9.1.2 Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох 9.1.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах 9.1.4 Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах 9.1.5 Агаарын бохирдлыг бууруулах талаар холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх 9.1.6 Агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах	Есдүгээр зүйл Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг
17.1 Агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, түүнчлэн хөдөлгөөнт эх үүсвэрийн төрөл бүрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, тэдгээрийг тодорхойлох аргыг стандартаар тогтооно.	Арвандолдугаар зүйл Агаар хамгаалахтай хэм хэмжээ
23.1 Аж ахуйн нэгж байгууллага нь ашиглалтанд орсон хугацааг харгалзахгүйгээр агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр нэг бүрээ хянах, агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмж багаж хэрэгслээр тоноглоно. 23.2 Агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах, эх үүсвэр бүрийг хяналтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглох, тэдгээрийн ашиглалтын байдалд тухайн салбарыг	Хорингуравдугаар зүйл Эх үүсвэрийг тоноглох

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

харьяалах, төрийн захиргааны төв байгууллага, сум дүүргийн Засаг дарга байгаль орчны байцаагч хяналт хийнэ.	
Газрын тухай хуулиас	
35.3.4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх; 55.1. Газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна. 55.2. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна.	35 дугаар зүйл. Газар эзэмшигчийн эрх, үүрэг 55 дугаар зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	
Төсөл хэрэгжүүлэгч нь тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх, төслийн ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх ёстой. Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох, үйл ажиллагааныхаа явцад доройтсон хөрсийг биологийн нөхөн сэргээлтийн стандартын шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээх, хөрсний ялзмаг, үржил шимийг тогтоох, доройтлоос хамгаалах зорилгоор гуу, жалга үүсэж болох газарт хаалт хамгаалалт хийх, ойжуулах ёстой.	7 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ
Байгалийн ургамлын тухай хуулиас	
7.1 Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.	Долдугаар зүйл Ургамлыг хамгаалах
Галын аюулгүй байдлын тухай хуулиас	
1. Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймэрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна.	Арван наймдугаар зүйл Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих нийтлэг шаардлага
Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам	
1. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэр, ахуйн бохир усаа ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх боломжгүй тохиолдолд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүйгээр урьдчилан цэвэрлэж,халдваргүйжүүлэн, бэлтгэсэн цэг талбайд байрлуулна. 2. Хаягдал ус зайлуулах цэгийг байгаль орчин, эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын шийдвэрээр тогтооно. 3. Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журмыг зөрчвөл “Байгаль хамгаалах тухай” болон “Усны тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.	Нэг Нийтлэг үндэслэл
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	
Төсөл хэрэгжүүлэгч нь уг хуульд заасны дагуу галын аюулгүй байдалд тавих шаардлагуудыг хангах болон ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулах ёстой.	28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцах ба үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах, хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ гаргуулах ёстой.	олгогчийн эрх, үүрэг
--	----------------------

Стандарт, норм, норматив

-	Дугаар	Нэр
1	MNS 5916:2008	Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт Техникийн шаардлага
2	MNS 5918:2023	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
3	MNS 5885:2008	Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ
4	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
5	MNS 5850:2019	Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
6	MNS4943-2011	Усны чанар, хаягдал бохир ус
7	MNS 3342:1982	Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах. Ерөнхий шаардлага
8	MNS 0900:2018	Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
9	MNS 3298:1991	Байгаль хамгаалал. Хөрс шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
10	MNS ISO 226 : 2003	Дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
11	MNS 5342:2007	Автомашинны зогсоол, ангилал. ерөнхий шаардлага
12	MNS 0017-0-0-06:1979	Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн нэр

“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төсөл

Төслийн зорилго: Төслийн хүрээнд Авдрант уулын цагаан тугалганы шороон ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн үр ашигтайн зэрэгцээ байгаль орчинд ээлтэй байх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг чухалчлан улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, үйлдвэрлэлийн хаягдал багатай шинэ техник технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шинэ дүрэм журам нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангахад энэхүү төслийн зорилго оршино.

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Баян могул” ХХК
Регистрийн дугаар	6400477
Улсын бүртгэлийн дугаар	9011800061
ААН-ийн үйл ажиллагааны чиглэл	Уул уурхай
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-020997
ААН-ийн хаяг	Улаанбаатар хот, СБД, 4-р хороо, Цэнтрүүм оффис, 4 давхар, 401 тоот
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангын хаяг	Байгаль орчны мэргэжилтэн Г.Бадамгарав, 80821128, gbadmaa1128@gmail.com
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлантай холбоотой мэдээлэл	
Төслийн БОННУ-ний тайланг Байгаль тандалт ХХК боловсруулж 2022 онд БОУАӨЯ-аар батлуулсан.	


Авдрантын цагаан тугалганы орд газар нь Төв аймгийн Эрдэнэ сумын Хушинга 4-р баг, Баяндэлгэр сумын Галуун 2-р багийн нутаг дэвсгэрт нийт 1314.72 га талбайг хамран орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн тийш 85 км, Эрдэнэ сумын төвөөс зүүн урагш 15 км зайд байрлана.

м 1 fj dZ1. 5 k3 k fj 5 0 2 L M 3 h MM t6 dZ q 2 dZ

№	Уртлаг, E	Өргөрөг, N
1	107° 59' 10.40"	47° 39' 30.50"
2	107° 59' 10.40"	47° 39' 08.00"
3	107° 58' 26.70"	47° 39' 08.00"
4	107° 58' 26.70"	47° 38' 54.81"
5	107° 59' 10.40"	47° 38' 54.81"
6	107° 59' 10.40"	47° 38' 28.40"
7	107° 59' 35.70"	47° 38' 28.40"
8	107° 59' 35.70"	47° 38' 11.60"
9	108° 00' 01.48"	47° 38' 11.60"
10	108° 00' 01.49"	47° 37' 28.60"
11	107° 59' 36.00"	47° 37' 28.60"
12	107° 59' 36.00"	47° 37' 45.60"
13	107° 59' 07.12"	47° 37' 45.60"
14	107° 59' 07.12"	47° 38' 08.50"
15	107° 58' 40.72"	47° 38' 08.50"

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн ТӨЛӨВЛӨГӨӨ

16	107° 58' 40.72"	47° 38' 30.82"
17	107° 57' 38.80"	47° 38' 30.82"
18	107° 57' 38.80"	47° 37' 59.60"
19	107° 57' 06.50"	47° 37' 59.60"
20	107° 57' 06.50"	47° 37' 42.46"
21	107° 56' 34.63"	47° 37' 42.46"
22	107° 56' 34.63"	47° 38' 16.20"
23	107° 57' 11.70"	47° 38' 16.20"
24	107° 57' 11.70"	47° 38' 44.90"
25	107° 57' 36.30"	47° 38' 44.90"
26	107° 57' 36.30"	47° 39' 01.80"
27	107° 57' 11.70"	47° 39' 01.80"
28	107° 57' 11.70"	47° 39' 22.50"
29	107° 56' 41.43"	47° 39' 22.50"
30	107° 56' 41.43"	47° 40' 01.77"
31	107° 58' 11.42"	47° 40' 01.77"
32	107° 58' 11.42"	47° 40' 31.77"
33	108° 00' 01.50"	47° 40' 31.76"
34	108° 00' 01.50"	47° 39' 47.30"
35	107° 59' 35.70"	47° 39' 47.30"
36	107° 59' 35.70"	47° 39' 30.50"



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

1.3. Орд ашиглалтын систем

Ордын геологийн тогтоц хөрсний зузаан, газар зүйн байрлал, хөрсний чулуулгийн шинж чанар зэрэг гол үзүүлэлтүүд болон уул-техникийн нөхцөлөөс нь хамааруулан уурхайд авто тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын систем сонгосон. Төслийн Техник-эдийн засгийн

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

үндэслэлд (ТЭЗҮ) тусгасны дагуу Авдрантын цагаан тугалганы ордын нийт олборлолтын дундаж гүн нь 5–6 метр орчим байна.

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй, ашиглалтын технологи	Хөрс, хуулалт	Ухаж, ачих ажил
		Тээвэрлэх
		Овоолго үүсгэх
	Олборлолт	Ухаж, ачих ажил
		Тээвэрлэх
		Шигших
		Агуулахад хураах

Үржил шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2м ээс ихгүй зузаантайгаар хуулна. Үржил шимт хөрсийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайгаас гадна талд үржил шимт хөрсний овоолгыг 2 м хүртэлх өндөртэйгөөр хийж үржил шимт хөрсийг хадгалах, арчлах, тээвэрлэлтийн стандартыг мөрдөж ажиллана.

Хөрс хуулалтын ажил: Хөрс хуулалтын ажилд 3.2 м³-ын утгуурын багтаамжтай урвуу утгууртай экскаватор ашиглан, 25тн даацтай автосамосвалын хослолоор шууд ачиж ил уурхайн ашигласан орон зайд, дотоод овоолго үүсгэх байдлаар хөрс хуулалтын ажил явагдана.

Элс олборлолтын ажил: Элс олборлолтын ажлыг 3.2 м³-ын утгуурын багтаамжтай урвуу утгууртай экскаватор ашиглан, 25тн даацтай автосамосвалын хослолоор элсийг мөргөцөгөөс шууд ачиж угаах үйлдвэрийн дэргэд байрлах шигшин ангилан, байрлуулна.

Ил уурхайн үндсэн хэмжээ

Доголын өндөр, доголын хажуугийн өнцөг, замын өргөн, ажлын талбайн хамгийн бага өргөн зэргийг тооцсоноор ил уурхайн хэмжээнүүдийг дараах байдлаар авч явна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ил уурхай
1	Ил уурхайн гүн /дунжаар/	м	5
2	Хөрс хуулалтын доголын өндөр	м	0.6-6.9
3	Элс олборлолтын доголын өндөр	м	0.5-2.6
4	Доголын хажуугийн өнцөг	градус	60
7	Авто замын өргөн	м	10
8	Авто замын налуугийн хэмжээ	промиль	80-100
9	Ажлын талбайн бага өргөн	м	15

1.3.1. Угаан баяжуулах технологи

Олборлосон элсийг скрубберт угаах төхөөрөмж болон шлюз, баяжуулах ширээний дамжлагаар угаан баяжуулдаг.

Баяжуулах цех нь нийт технологийн усны 81 %-ийг эргэлтээр, 19 %-ийг нөхөн сэлбэлтээр ашиглана.

Элс баяжуулах процессээс үүсэх хаягдал нь галь буюу том ширхэгтэй чулуу, шигшүүргээр шигшсэн элсний хаягдал байх бөгөөд хаягдлыг овоолго үүсгэн хадгалдаг.

№	Үзүүлэлт	Утга
1.	1 м³ элс угаахад шаардагдах технологийн усны зарцуулалт, м³	4.2
2.	1 м³ элс угаахад шаардагдах цэвэр усны зарцуулалт, м³	0.8
3.	Угаан баяжуулахад орж байгаа ус, м³ /цаг	315.2
4.	Угаан баяжуулахаас гарах эргэлтийн ус, м³/цаг	255.2

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.	Технологийн ус ашиглалтын коэффициент, %	81
6.	Угаан баяжуулах үйлдвэрийн хэрэгцээтэй усны хэмжээ, л/сек	16.7

1.3.2. Уурхайн ажиллах горим, хүчин чадал

Уурхай нь техник, тоног төхөөрөмжөө бүрэн хүчин чадлаар ашигласан тохиолдолд жилийн туршид 300–400 мян.тонн цагаан тугалга агуулсан элс олборлох боломжтой байна.

Төслийн техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д тооцсоноор уурхай нь ашиглалтын нөхцөлөөс хамаарч улирлын чанартай ажиллах бөгөөд жил бүрийн 5-р сарын 10 эхлэн 11-р сарын 10 хүртэл 6 сарын хугацаатай ажиллана. Төсөлд хоёр ээлжээр нийт 50 хүн ажиллана.

Одоогийн байдлаар уурхай нь хоёр ээлжийн нийт 40 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 20 хувь буюу 8 хүн нь орон нутгийн иргэд байна.

№	Уурхайн ажиллах горим	Үзүүлэлт	
1.	Хуанлийн хоног	365	өдөр
2.	Жилд ажиллах хоног	180	өдөр
3.	Баяр ёслол	6	өдөр
4.	Цаг агаарын хүнд нөхцөл тооцсон хоног	4	өдөр
5.	Жилийн ажлын өдөр	170	өдөр
6.	Ээлжийн үргэлжлэх хугацаа	12	цаг
7.	Хоногт ажиллах ээлжийн тоо	2	ээлж

№	Тоног төхөөрөмжийн төрөл	Марк	Тоо, ш	Зориулалт
1	Экскаватор	Hyundai R520-LC-9	1	Элс олборлолт
2		Hyundai R520-LC-9	1	Хөрс хуулалт
3		Hyundai-300	1	технолог ажил
4	Автосамосвал	Howo 336	6	Элс олборлолт
5	Автосамосвал	Howo 336	2	Элс шигшүүр
6	Автосамосвал	Howo 336	3	Хөрс хуулалт
7	Бульдозер	Komatsu D65	1	Хөрс хуулалт
8	Утгуурт ачигч	SDLG	1	Баяжуулах
9		Lonking	1	технолог ажил
10	Грейдер	GR 180	1	технолог ажил

1.4.Дэд бүтэц

1.4.1. **Зам харилцаа.** Хот суурин газартай ойр тул зам тээвэр, цахилгаан хангамж г.м дэд бүтэц сайн хөгжсөн хэсэгт байрладаг. Авдрантын цагаан тугалганы орд нь Улаанбаатар хотоос 84 км, Эрдэнэ сумаас 15 км зайд байрладаг. УБ хотоос Эрдэнэ сум хүртэл асфальтан замаар холбогдсон. Эрдэнэ сумын төвөөс төслийн талбай хүртэл 8.2 км энгийн шороон замаар явна.

1.4.2. **Цахилгаан хангамж.** Уурхайн цахилгаан хангамжийг төвийн эрчим хүчнээс хангана.

1.4.3. **Барилга байгууламж.** Уурхайн барилга байгууламжид оффис, ажилчдын амрах байр, хоолны газар, засварын талбай болон материал хадгалах агуулах багтана.

1.4.4. **Усан хангамж.** Төслийн хүрээнд дараах зориулалтаар ус ашиглана. Үүнд:

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Ажиллагсдын унд ахуй,
- Баяжуулах үйлдвэр,
- Зам, талбайн усалгаа, чийгшүүлэлт

Ажилчдын унд ахуйн хэрэглээ болон элс угаан баяжуулах үйлдвэрт шаардлагатай усны хэрэглээг өөрийн талбайд гаргасан нийт долоон ширхэг гүний худгаас хангадаг. Гүний худаг бүрийг тоолууржуулсан.

❖ **Ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ.**

Ордын унд ахуйн зориулалтаар ашиглах усны хэрэглээг тус ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд тооцсоноор 2025 онд уурхайн ажиллах хугацааг 170 хоногоор тооцлоо.

Уурхайн хэмжээнд хоёр ээлжээр нийт 50 хүн ажиллах бөгөөд нэг хүний хоногт ашиглах усны хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/301 дугаартай тушаалын хавсралтаар баталсан нэг хүний хоногт ашиглах усны норм буюу 150 л-ээр тооцлоо.

Хүний тоо	Нэг хүний хоногт ашиглах усны хэмжээ, л	Хоногт ашиглах усны хэмжээ, м3	Жилд нийт ажиллах хугацаа, хоног	Жилд ашиглах усны хэмжээ, м3
50	150	7.5	170	1,275.0

❖ **Ногоон байгууламжийн усалгаа.**

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023, 2024 онуудад уурхайн кемпийн урд хэсэгт нийт 2000 ширхэг хайлаас модыг шуудуулан тарьсан байгаа бөгөөд 2025 оны хавар 5-р сарын дунд үед уурхайн кемпийн хашаан дотор нийт 500 ширхэг хайлаас модыг суулгацаар шуудуулан тарихаар төлөвлөсөн.

Мод усалгааг тухайн модны онцлогт тохируулан урьдчилан төлөвлөсөн хуваарийн дагуу хийх бөгөөд шаардлагатай усны хэрэглээг гүний худгаас хангана.

Ногоон байгууламжийн усалгаанд ашигласан усны хэрэглээг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/301 дугаартай тушаалын 11-р хавсралтаар баталсан нэг ширхэг суулгац услах усны норм /40 л/-оор тооцлоо.

Модны тоо	Усалгааны норм, л	05-р сарын 15-аас 08-р сарын 30 хүртэл	Нэг удаа услахад ашиглах усны хэмжээ, м3	Нийт ашиглах усны хэмжээ, м3
2500	40	30 өдөр	100 м3	3,000 м3

❖ **Зам талбайн усалгаа**

Ил уурхайд шаардлагатай технологийн ус хангамжид уурхайн дотоод замын тоос дарах, ногоон байгууламж, талбайн усалгаа болон тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай усны хэрэглээ багтана. Ногоон байгууламжийн усалгааг БОНХАЖСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” А/301-р тушаалын 13-р хавсралт заасны дагуу “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д 1м2 талбайд 3л, “Технологийн хэрэглээ буюу зам, талбайн усалгаа”-д 1м2 талбайд 2л гэсэн нормыг тус тус баримталж ус хэрэглээний тооцоог хийсэн.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1.	Талбай	м ²	7000

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.	Норм	м ² /л	2
3.	Хоногт услах хэмжээ	ш	1
4.	Жилд технологийн зам талбай услах хоног	хоног	100
5.	Нийт ашиглах усны хэмжээ	м ³	1,400

❖ **Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны хэмжээ**

2025 оны уулын ажлын төлөвлөөгөөний Маягт-3-т тооцсоноор 120,840.0 тонн элс олборлон боловсруулахаар тооцсон.

Байгаль орчин, ногоон хөгжил, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ний өдрийн А-301 дүгээр тушаалаар баталсан “Ашигт малтмал баяжуулах, боловсруулахад хэрэглэгдэх усны норм”-ын дагуу тооцоход:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
6.	Тухайн жилд олборлох элсний хэмжээ	тн	120,840.0
7.	Норм	м ³	4.5
8.	Нийт ашиглах усны хэмжээ	м ³	543,780
9.	Эргэлтээр ашиглах усны хэмжээ, 81%	м ³	440,461.8
10.	Нөхөн сэлбэлтээр ашиглах усны хэмжээ, 19%	м ³	103,318.2

2025 онд төслийн хэмжээнд нийт 108,993.2 м³ ус ашиглахаар байна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ

2.1. Физик газарзүй, ландшафт

Төсөл хэрэгжих район нь Хэнтийн уулархаг нутгийн өмнөд хэсэгт орших ба морфологийн байдлаар дунд зэргийн уулархаг мужид хамаарна. Хамгийн өндөр цэг 2000 м нам цэг нь 1200 м байна. Харьцангуй өндөр нь районы хойд хэсгээр 250-300 м, дунд хэсэгт 200-250 м, өмнөд болон Баян-улааны массивт 350-600 м байдаг. Хэрлэн голын баруун эргийн өмнөд ба төв хэсэгт харьцангуй өндөр нь 150-200 м байна. Орографийн элементүүдийн ерөнхий чиглэл нь баруун урдаас зүүн хойш, харин районы баруун хойгуур орших Хэнтийн салбар уулсын хувьд баруун хойш чиглэсэн. Хэрлэн голын баруун эрэгт ойролцоогоор 80 км урттай 13-14 км өргөнтэй мезозойн депресс орших ба түүний хойд төгсгөлийн багахан хэсэг нь голын зүүн эрэгт байрладаг. Энэ депресст нүүрс агуулсан хурдас үүссэн байна. Голын зүүн хэсгийн рельеф нь өндөр уулархаг маш нийлмэл тогтоцтой.

Судалгааны талбайн орчимд Авдрант уул (далайн түвшнээс дээш 1810.8 м), Эрдэнэ уул (1815.7 м), Бэржин уул (1803.9 м) зэрэг өндөрлөгүүд байх ба зүүн урагшлах тусам өндөржилт нь намсаж, хамгийн нам цэг Хөх сүмийн ам (1601.0 м) болно.

2.2. Ус зүй. Ашиглалтын талбайн орчимд баруун талаар нь Хар хустын гол, зүүн талаар Тогостын гол урсана. Судалгааны талбайд хэдэн булаг шанд, гадаргууд ойрхон хөрсний устай хэсгүүдтэй юм. Ус агуулагч давхаргууд нь сул барьцалдсан хайргархаг чулуу, хайргаас тогтсон байна. Районы хойд хэсгээр усан сүлжээ сайн хөгжсөн. Энд Хэрлэн гол болон түүний баруун талын олон цутгалангууд оршдог. Голын хөндийд олон тооны хар ус, нуур болон намагжсан газрууд тохиолддог. Гольдролын өргөн 40-100 м, гүн нь 1-3 м орчим байдаг. Хэрлэн голын баруун цутгалангууд янз бүрийн хэмжээтэй байх ба тэдгээрийн томоохон нь болох Хужирын болон Хуцаагийн голууд нүүрстэй хурдсын дээгүүр урсдаг байна.

2.3. Цаг уур. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур нь эрс тэс хэлбэлзэлтэй, атмосферийн тунадасны хэлбэлзэл 193.4-297.4 мм бөгөөд жилийн дунджаар 220 мм хүрнэ. Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр ордог. Жилийн 4 улиралд хур тунадас орох өдрүүдийн тоо харилцан адилгүй. Хамгийн халуун 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард байдаг. Хамгийн их хур тунадас унадаг улирал зун, хамгийн бага унадаг улирал нь өвөл юм. Өвөл хөрс нь 3-4 м гүн хөлддөг.

2.4. Ордын геологийн тогтоц

Баруун Авдрант орд: Баруун Авдрант хөндий 4.0 км орчим үргэлжилнэ. Ёроолын өргөн нь 10-500 м. Доод хэсгээрээ хошуу туугдасын хурдас үүссэн. Яргайтын хөндийн террас үүссэн. Хөндийн дагуух налуу 0.004-0.092.

Орд нь пролюви-аллювийн гарал үүсэлтэй, “В” төрөлд хамаарна. Ордын үйлдвэрлэлийн хэсэг 5-27-р хайгуулын шугамын хооронд үргэлжлэх ба дээд хэсгээрээ хоёр нарийхан урсгал болж салаалан, 45 м дээшгүй өргөнтэй байна. Үйлдвэрлэлийн хилийн урт нь 3125 м.

Орд нь хөндий татмын хэсгээр нэг пласттай, тасралтгүй үргэлжлэлдэг. Ордын өргөн дээд хэсгээрээ харьцангуй нарийхан /20-100 м/ дунд, доод хэсгээр 240-400 м. Ордын зузаан нь 0.5-4.0 м хооронд хэлбэлздэг. Ашигтай зузаалаг аллюви-пролювийн хуримтлалд оршдог. Эдгээр хурдас нь грави бүхий элсэнцэр, элс, шавранцар хайрга байна. Эдгээр нь хоорондоо хэмхдэст материалын элэгдэл, сортлогдсон байдлаараа ялгагдана. Ордын дээд үеүдээр ихэвчлэн элсэнцэр үүссэн, харин доод үеүдээр нь хайргархаг элс, хайрга байрладаг. Элсэнцэр, хайргын эдгээр үеүд хөндийн эхнээс амыг хүртэл жигд үргэлжилнэ. Касситеритийн үйлдвэрлэлийн агуулга нь хайргархаг элс, элсэнцэр зарим тохиолдолд шавранцаруудад хамаардаг. Хөндийн дээд хэсэг болон зүүн хэсгээр нь бараг төгсгөлөө хүртэлх ашигт үеийн ул суурь дээд хэсгээрээ II шугам хүртэлх ашигт үеүд дресва болтлоо бутарсан боржин, хайгуулын IV шугамаас доош хайргархаг дресва, доод дөрөвдөгчийн шавар, зарим үед хайгуулын IX шугам хүртэл хэмжээнд сул суурийн чулуулаг болсон байна. Ашигт үеийн ихэнх нь аллювийн хурдас зэрэг хуурамч ул суурьтай.

Хэсгийн геологийн тогтцын хувьд магмын, тунамал, хувирмал бүхий л төрлийн чулуулаг тархсан. Хөндийн зүүн эрэг кембрийн боржин баруун эргээр нь палеозойн эвэр хуурмагжсан боржин тархсан. Баруун-Авдрант хөндий дөрөвдөгч-цэрдийн хурдас, орчин үеийн делюви-пролювийн хурдаснаас тогтсон. Хөндийн дээд талаар боржингийн угагдлын гадаргуу дээр делюви-пролювийн хурдсаар дүүргэгдсэн сэвсгэр хурдасны зузаан 0.5-6.0 м-т хэлбэлзэнэ. Эдгээр нь орчны боржингуудын валун, хайрга, шебень, дресва агуулсан элс, элсэнцэр шавранцараас тогтдог. Хөндийн дагуу дээд хэсгээс 2.0 км орчимд сортлогдсон сэвсгэр хурдас байх ба хэмхдэс чулуулаг нь илүү мөлгөржсөн аллюви-пролювийн шинж чанартай.

Хөндий доошлох тусам доод дөрөвдөгчийн улаан өнгөт хурдасын угагдсан гадаргуу дээр сэвсгэр хурдас байрлана. Зүүн хажуугаар нь боржин илэрсэн. Аллюви-пролювийн тунадас хуримтлах үед хайргатай элс элсэнцэр бий болсон бөгөөд ховроор хайрга, валун агуулсан шавранцар оролцдог. Тэдгээрийн зузаан 1-8 м-т хэлбэлздэг. Хөндийн амсарт хошуу туугдас үүссэн,

харин хил хязгаар нь бүрхэг. Эндэх зүсэлтэд дээрхи ялгасан төрлүүдийн ээлжлэн дараалсан үеүд 15 м хүртэл зузаан ажиглагддаг.

Авдрант орд: Авдрант хөндий 12 км үргэлжилнэ. Хөндийн өргөн нь дээд хэсгээрээ 50 м, доод хэсгээрээ 500 м. Баруун, зүүн бортуудын хуримтлалын дэнж 1.5-4.0 м өндөртэй, 150-200 м өргөнтэй. Татам нь тэгш, намагжсан, жалгын өргөн 1-2 м, гүн 0.5 м. Хөндийн хажуу нь 10-200, олон жижиг жалгаар хэрчигдсэн, төгсгөлийн хэсэг нь хошуу туугдасын хурдсаар хучигдсан. Хөндий нь тэвш маягийн хөндлөн зүсэлттэй. Хөндийн дагуух налуу дээд хэсгээрээ 0.03, доод хэсгээр 0.01 байна.

Авдрант боржингийн массивт хамаарах хөндий зүүн урагш чиглэлтэйгээр Бөөрөлжүүтийн нурууны өргөгдлөөр хязгаарлагдаж оршдог. Нийт урт нь ойролцоогоор 12 км. Эдгээрт баруун, зүүн талаас нь хэд хэдэн багавтар жалгууд нийлдэг. Шороон орд нь дээд хэсгээрээ пролюви-аллювийн гаралтай бүлэгт, доод хэсгээрээ аллювийн хурдсанд хамаарна. Нийт хөндийн хэмжээгээр 3830 м урт сунасан 50-250 м өргөнтэй байна. Шороон ордын хөндийн дээд хэсгээр 20 м хүртэл нарийсч делювийн хуримтлал бөөгнөрсөн хурдасд тархдаг. Ашигт үеийн дундаж зузаан хэсэглэлүүдийн хэмжээнд 0.8-1.5 м-т хэлбэлзэж, харин хөрсний дундаж зузаан 0.5-2.7 м-т байна.

Ордын өргөн ба зузаан нь тогтвортой. Хөндийн дунд хэсгээр V хайгуулын шугамын орчим ордын өргөн 400 м хүрдэг, харин бусад хэсгүүдэд дунджаар 60-70 м байна. Касситеритийн хамгийн баялаг агуулга ордын дээд хэсгээр /58-аас дээш/ болон жалгын зүүн хэсгээр касситеритийн агуулга дунджаар 390-510 г/м³ байна. Ордын дээд дунд хэсгээр касситеритийн агуулга багасч 360-400 г/м³-д хэлбэлзэж дунджаар 380 г/м³ болдог.

Авдрант, Жанчивлан, Элстэйн бүлэг шороон ордууд ойролцоо нөхцөлтэй. Шороон ордууд нь гарал үүслийн хувьд аллювийн төрөлд багтах бөгөөд хөндийн болон хонхор газруудын шинжийг агуулсан байдаг. Морфологийн онцлогоор туузан маягийн тогтоцтой. Авдрант район нь Дагуурын өргөгдлийн Хэнтийн өмнөт төгсгөлийн мужид орно. Районы бүх үндсэн морфоструктурууд нь зүүн хойт чиглэл болон геологийн нөхцөлтэй зохицож явдаг. 1800 м дээш өндөржилттэй усан сүлжээнүүдэд эртний тэгшрэлийн гадаргуу бүхий хэсгүүд тэмдэглэгдсэн. 1600-1800 м төвшинд огцом хэрчигдсэн рельефтэй. 1600 м доош хэсэгт тэгш хэлбэрийн рельеф үүссэн. Рельефийн гадаргуугаар дараах төрлийг ялгасан. Хагарал эвдрэлээр тектоникийн гадаргуу үүссэн. Эдгээр гадаргуу Яргайт, Зүүнбаянгийн хөндийд тогтоогдсон. Эрози, денудацийн процессийн үрээр үүссэн гадаргуу: Эхлээд голын хөндийн хажуугаар үүссэн. /эгц, дунд, налуу/ Денудацийн процесс уул-нуруудын хажуугаар үүссэн. Эдгээрийн дунд огцом, дунд, налуу хэлбэрүүд тогтоогдсон. Сэвсгэр хурдсын зузаан 1-3 м налууугийн уналын өнцөг 50 хэмжээнд байв. Хуримтлалын гадаргуу усны үйл ажиллагаагаар үүссэн. Эдгээрт нам, өндөр татам, татам дээрх террасууд орно. Татам-голидролууд зарим хэсэгтээ намагжсан. Хөндийн дээд хэсэг нь хөндлөн огтлолоор V маягтай. Харин дунд доод хэсгээрээ тэвш хэлбэртэй. Судгийн гүн 1.0 м өргөн нь 0.5-3.0 м. Хуримтлалын татамын дээрх дэнжүүд бүхий л хөндийнүүдэд 1-2 м-ээс 5.0 м өндөртэй болох нь тогтоогдсон.

2.5. Ордын гидрогеологийн нөхцөл

Ашиглалтын талбайн хувьд гидрогеологийн үндсэн нөхцөлийг нь гол ус агуулагч үе нь, аллювиаль хурдсанд агуулагдана. Ус агуулагч аллювиаль хурдас нь Хар хустын гол, Тогостын голын хөндийн татмын хэмжээнд өргөн тархсан байдаг. Ус агуулагч хурдас нь бага хэмжээний валунтай элс агуулсан хайрга хайрганцар хурдаснаас бүрддэг. Усны элбэг хэсэг нь татмын хэсэгт ерөнхийдөө их байдаг. Газрын доорх усны урсцын хурд хоногт 55.6-59.7 м/хон, дунджаар 57.6 м/хон. Газрын доорх ус болон хөрсний усны хоорондох уялдаа холбоог тогтоох зориулалтын судалгаа хийгдээгүй боловч хайгуулын шугамаар Хар хустын гол, Тогостын голын хөндийнүүдийн хажуу далавчинд газрын доорх усны ул (зеркала) агаарын тунадасны уналтын болон үерийн хэмжээнээс хамаарч үе үе өөрчлөгдөж байдаг. Газрын доорх усны химийн шинжилгээгээр 0.2-0.4 г/л эрдэсжилтийн хэлбэлзэлтэй цэнгэг ус гэдэг нь тогтоогдсон.

Аллювын хурдсан дахь газрын доорх ус нь нүүрсхүчил, хүчил, шүлт, сульфат зэрэг шинж чанарт автагдаагүй. Усны сорьцын химийн шинжилгээний үр дүнгээр компонентуудын агуулга,

усны тархалтын хүч, хэмжээ, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хүрэлцээтэй доогуур урьдчилан тооцсон техникийн нөхцөлийн хэмжээгээр байх бөгөөд газрын доорх усны хүчилтөрөгчийн тархалтад автагдаагүй байна.

Газрын доорх ус болон хөрсний усны хоорондох уялдаа холбоог тогтоох зориулалтын судалгаа хийгдээгүй боловч хайгуулын шугамаар голын хөндийн хажуу далавчинд газрын доорх усны ул (зеркала) агаарын тундасны уналтын, болон үерийн хэмжээнээс хамаарч үе үе өөрчлөгдөж байдаг. Усны найрлага нь гидрокарбонат-кальци-натритай, гидрокарбонат-магни, гидрокарбонат-кальци-магнитай, 4.5 мг хатуулагтай. Аллювын хурдсан дахь газрын доорх ус нь нүүрсхүчил, хүчил, шүлт, сульфат зэрэг шинж чанарт автагдаагүй. Усны сорьцны химийн шинжилгээний үр дүнгээр компонентуудын агуулга, усны тархалтын хүч, хэмжээ, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хүрэлцээтэй доогуур урьдчилан тооцсон техникийн нөхцөлийн хэмжээгээр байх бөгөөд газрын доорх усны хүчилтөрөгчийн тархалтанд автагдаагүй байна. Энэ мэтчилэнгээр ордын хувьд бүхэлдээ гидрогеологийн хүндрэлийн зэргээр их биш гэж дүгнэсэн байна. Ордын усны үндсэн эх үүсвэр нь голын хөрсний устай гидравлик холбоотой газрын доорх ус, аллювиаль хурдсан дахь устай үеүд юм. Олон жилийн цэвдэг, усаар тэжээгдсэн татмын ордын хувьд бамбалзуур байхгүй нь тааламжтай нөхцөлд тооцогдоно.

2.6. Ургамал амьтны аймаг.

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг нь Монгол орны газар зүйн мужлалаар Төв халхын хээрийн мужид хамрагддаг бөгөөд Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол дагуурын хээрийн тойрогт хамаарна. Тус бүс нутагт урд өмнө хийсэн судалгаа, ном бүтээлээс магадлахад “Авдрант” цагаан тугалганы орд газар түүний орчимд 7 багийн 28 зүйлийн хөхтөн амьтад, 12 багийн 80 зүйлийн шувууд бүртгэгдсэн байна.

Ургамлын аймгийн хувьд тус район дундад халхын хээрийн тойрогт хамаарна. Энэ тойрогт Хангайн нуруунаас зүүн тийш, Төв Монголын боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бүхий ухаа гүвээрхэг тэгшивтэр нутгууд хамаарна. Тойргийн хэмжээнд нийт 791 зүйлтэй бөгөөд ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлог багатай, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр байрлах тул Төв Азийн Монгол хошуу болоод Дагуурын хээрийн, зарим нь цөлөрхөг хээрийн, бас умардын уулсын элементүүд ч оролцоно. Зөвхөн энэ тойрогт тархсан Халх намуу (*Papaver rubroaurantiacum subsp. chalchorum*) хэмээх ганц зүйл унаган ургамал тохиолдоно (*f ts dz g ts dz l t t t t f l s dz ts g O dz l O ts 7 O dz l r dz M dz MM g q 2 dz l M dz M o в O 2 n O dz . f . v ts g O dz O dz , r .*

2023 онд Төв аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төвөөс хийсэн Эрдэнэ сумын бэлчээрийн ургамлын төрөл, зүйлийн бүрдлийн судалгаагаар тус сумын нутаг дэвсгэрт дараах 21 зүйлийн бэлчээрийн ургамал бүртгэгдсэн байна.

m f f dz 11 g l v ts g O dz dz r dz l f 2 dz q 2

Д/д	Ургамлын латин нэршил	Ургамлын монгол нэршил	Ургамлын өндөр
1.	<i>Agropyron cristatum</i> (L)P.B	Саман ерхөг	10
2.	<i>Artemisia Adamsii</i> Bess.	Адамсын шарилж	10
3.	<i>Arenaria capillaris</i> Poir.	Хялгасан дэвхэргэн цагаан	6
4.	<i>Artemisia changaica</i> Krasch.	Хангайн шарилж	10
5.	<i>Artemisia frigida</i> Willd.	Агь	11
6.	<i>Artemisia rutifolia</i> Steph. Ex Spreng.	Шаргал шарилж	11
7.	<i>Aster alpinus</i> L.	Тагын гол гэсэр	9
8.	<i>Cleistogenes squarrosa</i> (Trin.) Keng.	Дэрвээн хазаар өвс	6
9.	<i>Carex pediformis</i> C.A. Mey.	Зогдор улалж	6
10.	<i>Echinops latifolius</i> Tausch.	Өргөн навчит тайжин жинс	7
11.	<i>Goniolimon speciosum</i> (L.) Boiss	Гоо ёлт	6
12.	<i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.	Том цэцэгт дааган сүүл	9
13.	<i>Leontopodium ochroleucum</i> Beauvd.	Цайвар шаргал цагаан туруу	7
14.	<i>Linaria buriatica</i> Turcz.	Буриад хонин зажлуур	8

15.	Plantago minuta Pall.	Бага таван салаа	6
16.	Potentilla acaulis L.	Ишгүй гишгэнэ	6
17.	Potentilla bifurca L.	Имт гишгэнэ	6
18.	Stellera chamaejasme L.	Одой далан түрүү	7
19.	Stipa krylovii Roshev.	Креловийн хялгана	14
20.	Taraxacum mongolicum Hand-Mazz.	Монгол багваахай	7
21.	Veronica incana L.	Буурал ганд бадраа	7

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөлөл

Тоосны бохирдол.

Хөрс хуулах, ашигт малтмал олборлох, тээвэрлэх ажлын үед, гадаад болон дотоод овоолго болон эвдэрсэн газрын сул шороо салхинд хийсэн тухайн орчинд тоосжилт үүснэ.

Хорт хийн бохирдол.

Уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах угаарын хий (CO), азотын дутуу исэл (N₂O), хүхэрлэг хий (SO₂) зэрэг хорт хий нь тухайн орчны агаарын чанарт нөлөөлнө.

3.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл

Газрын эвдрэл.

Уурхайн ашигт малтмал олборлох малталтын талбай, хөрсний овоолго үүсгэх хэсэг, гадаад болон дотоод тээврийн зам, уурхайн барилга байгууламж зэргийг барьж байгуулах, ашиглах явцад газрын гадарга, хөрсөн бүрхэвч эвдэрч байгалийн унаган төрхөө алдана.

3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагааны явцад карьер болон овоолгууд, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих үед тухайн орчны ургамлан бүрхэвч хөрстэй цуг хуулагдан устана. Мөн замын тоос, шороо, авто машины хөдөлгүүрээс ялгарах хорт хий зэргээр эргэн тойрны ургамлан нөмрөг дарагдах, бохирдох, тухайн орчны ургамлын өсөлт удаашрах, төрөл зүйлийн тоо буурах, өөрчлөгдөх эрсдэлтэй.

3.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл

Тухайн бүс нутгийн хөхтөн амьтдын тархац нутаг хумигдах, тоо толгой буурах, хүн, машин техникийн хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэргээс амьтад дайжих г.м амьтны аймагт шууд биш ч дам байдлаар сөрөг нөлөө үзүүлнэ.

3.5. Газрын гадарга болон гүний усанд учруулах сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын унд ахуйн хэрэглээ, ногоон байгууламжын усалгаа, зам талбайн тоосжилт дарах болон ашигт малтмалыг баяжуулах үйлвэрийн зориулалтаар ус ашиглана. Төсөлд нийт долоон гүний худаг ашиглаж байна.

Баяжуулах үйлдвэр нь нийт технологийн усны 81 хувийг эргэлтээр, 19 хувийг нөхөн сэлбэлтээр ашигладаг.

Иймд төслийн үйл ажиллагаанаас гүний усанд хамгийн их нөлөө үзүүлэхээр байгаа бөгөөд гүний усны түвшин буурснаар тухайн орчны гадаргын болон хөрсний усны түвшин буурч, нөөц багасах эрсдэлтэй.

Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- ❖ Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө,
- ❖ Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүх л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Төслийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний нийт төсөв 16,534,000 [арван зургаан сая таван зуун гучин дөрвөн мянга] байна.

м.т.ф.д.13.2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль хамгаалах төлөвлөгөө	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	7,350.0
3	Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	2,600.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	600.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	800.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,184.0
9	Нийт зардал	16 534.0

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо шир-хэг	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх төлөвлөгөө								
БО,ХАБЭА-тай холбоотой хууль, дүрэм журмын шаардлагыг бүрэн хангаагүйгээс эрх зүйн зөрчил бий болох, эрсдэл үүсэх	Тухайн жилд байгаль орчинтой холбоотой уурхайд байх шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж ажиллах	Төслийн хэмжээнд	-	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль - Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль - Газрын тухай хууль - Усны тухай хууль -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - “Журам батлах тухай” БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 дугаар тушаал /Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам/ - Байгаль орчны хамгаалал. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм. MNS 4219:1994
	Гамшигийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн хэмжээнд	-	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он	
	Байгаль орчны аудитын тайланг тогтсон хугацаанд хийлгэх	Төслийн хэмжээнд	-	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он	
	Жил бүр байгаль орчинтой холбогдолтой төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх	Төслийн хэмжээнд	-	-	Тухайн жилийн БОМТ-ний зардал		2025 он	

Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Хөрс хуулах, элс олборлох, ачиж тээвэрлэх, буулгах, овоолго байгуулах үед сул шороо болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоос шороо дэгдэх	Салхины зонхилох чиглэлд мод тарих ногоон зурвас үүсгэх	Ажиллагс-дын суурин орчимд	ш	500	Нөхөн сэргээлтийн зардалд тусгав.	2025 он	- Агаарын тухай хууль. - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Хог хаягдлын тухай хууль. - Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016
Хүнд даацын машин техник, уурхайн ажилчдын хэрэгцээнд ашиглаж буй автомашины хөдөлгүүрээс ялгарах хорт хий агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Уурхайд ашиглаж байгаа бүх тээврийн хэрэгсэлд	ширхэг	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	- Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008
	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу агаарын чанарын мониторинг хийх, дотоод хяналт явуулах	Төслийн хэмжээнд			Үйл ажиллагааны зардал	2025 он	

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Ахуйн хог хаягдлыг зориулалтын бус талбайд, ил задгай удаан хадгалснаас орчин бохирдох, таагүй үнэр гарах	Ахуйн хог хаягдлыг дахин ашиглах, ашиглахгүйгээр нь ангилан ялгаж, дахин ашиглагдахгүй хог хаягдлыг зөөвөрлөх, зайлуулах, устгах арга хэмжээ авах, дахин ашиглах хог хаягдлыг эргүүлэн ашиглах эсхүл дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Ажиллагс-дын суурин	-	-	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	
	Хог хаягдал хадгалах түр цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Хог хаягдлын цэг	удаа	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардалд тооцож оруулав.	Улирал бүр	

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Хог хаягдлыг ил задгай шатаахгүй байх, хуванцар, нийлэг материал шатаахгүй байх	Хог хаягдлын цэг, ажиллагсдын суурин	-	-	ҮАЗ	ҮАЗ	Тогтмол	
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга эвдрэх, орчны ландшафтын төрх өөрчлөгдөх	Хөрс хуулалт болон овоолгод өртөх талбайн үржил шимт хөрсийг тусад нь байршуулж, стандартын дагуу хадгалах, нөхөн сэргээлтэд ашиглах	Төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тусгасны дагуу	м ³	-	ҮАЗ	ҮАЗ	Хөрс хуулалтын ажил хийгдэх бүрт тогтмол	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,
	Ашиглалт явуулж дууссан талбайд дотоод овоолго, нөхөн дүүргэлт, хэвгийжүүлэлтийн ажил хийх		га	3	Нөхөн сэргээлтийн ажлын зардалд тооцож оруулав.		2025 он	- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5915:2008 - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам гаргах, хөрс, ургамал талхлагдах, газар эвдрэлд орох	Төслийн талбайн хэмжээнд замын тогтсон маршрут тогтоож, түүнийг салаалах, өргөсөхөөс хамгаалан замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх, зам засах, сайжруулах ажлыг тогтмол хийж байх	Гадна болон дотоод тээврийн зам	ш	50	10	500.0	2025	газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4597:1998 - MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. - MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
	Хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэх, хязгаарлах үүднээс мод тарих, ногоон зурвас үүсгэх	Ажиллагсдын суурин орчимд	ш	500	Үйл ажиллагааны зардал		Жил бүр	
Авто засварын газрын техникийн тос тосолгооны материал асгарснаас хөрс бохирдох	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллах	Төслийн хэмжээнд	-	-	Үйл ажиллагааны зардал		Жил бүр	

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Авто зогсоолыг хатуу хучилттай болгох	Авто зогсоол	Га	-	-	1,500.0	2025 он	
Шаардлага хангахгүй нүхэн жорлон ашигласнаар хөрс бохирдох, улмаар газрын доорх ус бохирдох	Бохир усны цооногийг битүүжлэл сайтай болгож бохир соруулах машинаар тогтмол соруулж байх	Төслийн хэмжээнд	-	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он	
Гадаргын болон газрын гүний усанд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Элс угаан баяжуулаад шаардагдах сэлбэлтийн усыг гүний худгаас татаж ашиглах учир газрын доорх усны нөөцөд нөлөөлөх	Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах	Усан орчин	-	-	-	-	Тогтмол	-Усны тухай хууль, - Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм
	Ус ашиглалтын тайлан мэдээ хөтлөх, холбогдох төрийн байгууллагад хүргүүлж байх	Төслийн хэмжээнд	-	-	ҮАЗ	ҮАЗ	Жил бүр	- Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам - Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Ахуйн бохир усны цооног хальж ойр орчмын хөрс, улмаар бага гүний усыг бохирдуулах	Улирал бүр ундны усны эх үүсвэрээс дээж аван итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	Гүний худаг	ш	-	ОХШХ-ийн зардалд тусгасан		Улирал бүр	шаардлага. MNS 3342:1982 - Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010
	Уурхайн үйл ажиллагаа явуулж байх хугацаанд хоёр болон түүнээс дээш удаа ундны усны эх үүсвэрээс дээж аван итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	Төслийн ОХШХ-ийн хүрээнд	-	-	ОХШХ-ийн зардалд тусгав.		2025 он	- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 - Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2015
	Эргэлтийн усны нуурыг хамгаалан далан хийх, уурхайн талбайд мөн үерийн уснаас хамгаалах далан, суваг, шуудуу хийх	Төслийн хэмжээнд	-	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он	
Ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Уурхайн олборлолт, овоолго, зам, барилга байгууламжийн талбайн ургамал бүрхэвч дарагдах, талхлагдах	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэх, хадгалах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу	-	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он	-Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5915:2008 - Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага. MNS 5918:2008
	Биологийн нөхөн сэргээлтийн туршилт судалгааны талбайг одооноос бий болгох хэрэгтэй бөгөөд нөхөн сэргээлтэд ашиглах олон наст өвслөг ургамал болон мод, сөөг, сөөгөнцөр ургамлыг нөхөн сэргээлтэд ашиглах	Төслийн хэмжээнд	га,	6	Нөхөн сэргээлт ногоон байгууламжын зардалд тусгав.		2025 он	
	Ургамлын мониторинг, судалгаа шинжилгээ хийх	Төслийн талбайн ойр орчим	-	-	ОХШХ-ийн хөтөлбөрт тусгав.		2025 он	
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ								
Уурхайн лицензийн эвдрэлд өртөх	Өвс тэжээл нөөцлөн өвөл, хаврын улиралд тавьж	Төслийн талбайн ойр орчим	ширхэг	100 боодо л өвс	100*25.0 мян.төг буюу 2,500.0 мян.төг		2025 оны өвөл 2-р сард	- Амьтны тухай хууль - БОНБУ тухай хууль

талбайн зарим хэсэгт амьдарч байсан сээр нуруугүй болон сээр нуруутан амьтад үгүй болж, гүйдлийн махчин болон туруутан амьтны гүйдлийн зам хаагдах, ус намгийн нүүдлийн шувуу бууж амрах, хооллох талбай зэрэг хумигдах сөрөг нөлөөтэй	өгөх, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх							
	Амьтан унаж осолдохоос хамгаалах хашаа хамгаалалт барих	Лицензийн хүрээний гадуур	км	-	-	ҮАЗ	2025 он	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал 4,000.0 мян.төг								

1.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын явцад олборлолт явуулсан талбайд дотоод овоолгоор дүүргэлт хийж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг олборлолттой зэрэгцүүлэн үе шаттайгаар гүйцэтгэдэг. Энэхүү нөхөн сэргээлтийн аргачлал нь ашиглагдаж дууссан ордын дотоод орон зайд хөрс болон хуулсан материалыг буцаан байршуулж, уурхайн эвдрэлд орсон талбайг хэвийн байдалд оруулах нөхцөлийг бүрдүүлдэг.

2024 оны маркшейдрийн хэмжилтээр уурхайн газрын ашиглалт, нөхөн сэргээлтийн байдал нь дараах байдалтай байна. Үүнд:

- Олборлолт явагдсан нийт талбай – 17.0 га
- Хөрсний гадаад овоолго үүсгэсэн талбай– 4.0 га
- Технологийн зам, хөндлөн гарц – 1.2 га

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө


— Дотоод овоолгоор дүүргэлт хийсэн талбай– 9.5 га

— Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай- 6.8 га

2024 онд нийт 6.8 га талбайд, дунджаар 6.0 метрийн гүнтэй, нийт 408,000 м³ эзлэхүүнтэй хэсэгт дотоод овоолгоор дүүргэлт хийж, талбайг тэгшлэх, хэлбэршүүлэх ажлуудыг гүйцэтгэн, техникийн нөхөн сэргээлтийн ажил амжилттай хэрэгжүүлсэн болно.

Уг нөхөн сэргээлтийн ажил нь уурхайн ашиглалттай зэрэгцэн үе шаттайгаар явагдсан бөгөөд олборлолт дууссан блокуудын дотоод орон зайд уулын ажлын явцад хуулсан хөрс, чулуулгийн дүүргэлтийг зохих хууль, журам, стандартад нийцүүлэн буцаан байршуулж, тухайн бүсийн байгалийн хөрсний хэв шинж, гадаргын хэлбэрт дөхүүлэн хэлбэржүүлэлт хийсэн.

Тус техникийн нөхөн сэргээлтийн ажлыг Төв аймгийн Байгаль орчны газар, Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын комисст газар дээр нь хүлээлгэн өгсөн.



**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт	Ашиглалт явуулж дууссан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж, хэлбэршүүлэлт, нягтруулалт хийнэ.	га	3 га	ҮАЗ	ҮАЗ	Олборлолтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн хийнэ.	-MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг үржил шимт хөрсөөр хучих ажил хийнэ.	га	3 га	ҮАЗ	ҮАЗ	Техникийн нөхөн сэргээлт бүрэн хийгдэж дууссаны дараа хийнэ.	- MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага - MNS 5918:2008
Биологийн нөхөн сэргээлт	2024 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд орон нутгийн онцлогт тохирсон олон наст ургамал тарина.	га	7 га	6,600	6,600.0	Үржил шимт хөрс тараах ажлыг дууссаны дараа эхлүүлнэ.	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага - “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” (БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаал)
“Тэр бум мод”	Уурхайн кемпийн урд хэсгийг хашаалан 0,12 га	ширхэг	500	1 ш суулгац*1.5 мян.төг,	750.0	5-р сарын дунд үеэр	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

үндэсний хөтөлбөрийн хүрээнд	талбайд хайлаас модыг суулгац (4-5 нас) хооронд 25 см зайтайгаар шуудуулан тарина.						
Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал 7,350.0 мян.төг							

4.3. Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Сумын төвд ашиглагдахаа больсон том уурын зуухны барилгыг нураах, хогийн цэг рүү тээвэрлэх /Орон нутгийн саналаар/	ш	1	600.0	600.0	2025 оны хавар	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль - Усны тухай хууль - Амьтны тухай хууль
Ашиглалтын талбайтай зэргэлдээ орших хуучин уул уурхайн олборлолтын улмаас эвдрэл үүссэн талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийх /Багийн иргэдийн саналаар/	га	2	ҮАЗ	ҮАЗ	2025 онд	
Орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын чадавх, менежментийг сайжруулах зорилгоор техникийн туслалцаа үзүүлэх	-	-	-	2,000	2025 онд	
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал- 2,600.0						

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Уурхайн нөлөөллийн бүсийн иргэдэд өвс, тэжээл тараах	ш	100 боодол өвс	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгав.		2025 оны өвөл 2-р сард	“Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн лицензийн талбай дотор одоогийн байдлаар газар дээр ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй. Цаашид төсөл хэрэгжүүлэх явцад газар доор ямар нэгэн түүх соёлын дурсгал илэрсэн тохиолдолд тухайн төслийн үйл ажиллагааг түр зогсоож Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу ГТГ, ШУА-ийн Археологийн хүрээлэнд урьдчилан мэдэгдэж, мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах, малтлага судалгааны ажлыг хийлгэж, холбогдох байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна.

4.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хамрах хүрээ	Хэмжих нэгж, Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж
1. Байгалийн үзэгдлээс үүсч болзошгүй осол эрсдэл						
Эрчимтэй орсон хур тунадасны нөлөөгөөр гэнэтийн үер үүсэх, улмаар уурхайн карьер усанд автах, үүнээс шалтгаалан уурхайн хэвийн үйл ажиллагаа зогсох, дэд бүтэц, барилга байгууламж үерт автан эвдэрч сүйдэх, карьерын хана, далан	Ус тунаах болон цэвэршүүлэх далангийн усны тувшнийг тогтмол хянах	Үйл ажиллагааны явцад	-	ҮАЗ	ҮАЗ	2025 он
	Үер усны улмаас далан сэтэрсэн тохиолдолд уурхайн аваар устгах төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авч цэвэрлэх	Уурхайн хүрээнд	-	ҮАЗ	ҮАЗ	Тухай бүрт

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

нурах, уурхайн эдэлбэр орчмын хөрс элэгдэх, хүний амь нас эрсдэж болзошгүй. Хүчтэй үер нь хөрсний нуруулт, гулсалтыг үүсгэх магадлалтай	Уурхайн барилга байгууламж бүрт галын хор байрлуулж хэвийн ажиллагааг тогтмол хянаж бүртгэдэг байх	Уурхайн хүрээнд	-	ҮАЗ	ҮАЗ	2025 онд уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хугацаанд	
Төслийн талбай нь газар чичирхийллийн мужлалаар 8 баллын бүсэд буюу хүчтэй газар хөдлөх магадлалтай бүсэд багтдаг. Газар хөдлөлтийн улмаас уурхайн хана, овоолго нурах, дэд бүтцийн барилга байгууламж эвдэрч сүйдэх, хүний амь нас, эрүүл мэнд эрсдэх аюултай	Уурхайн “Гамшгийн эрсдлийн үнэлгээ”-ний хүрээнд “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан Төв аймгийн онцгой байдлын газраар батлуулах мөрдөж ажиллах	Уурхайн хүрээнд	-	-	-	2025 онд	
	Ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлэх	Уурхайн нийт ажилчдад	40-50 хүн	100.0	100.0	2025 онд	
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гаргах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Компанийн бодлогын түвшинд зохицуулах	-	ҮАЗ	ҮАЗ	2025 онд	
2. Үйл ажиллагааны буюу ил уурхай, баяжуулах үйлдвэр, хүний буруутай үйлдлээс үүсч болзошгүй осол, аюул							
Техник тоног төхөөрөмжийн осол аваар гарснаар хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, техник хэрэгсэл эвдрэх, гэмтэх	Тоног төхөөрөмж бүр технологийн горимд нийцсэн буюу уг үйлдвэрлэлийн зориулалттай, ашиглалтын заавар, паспорттай байх, аливаа засвар үйлчилгээ	Уурхайн хүрээнд	Уурхайд ашиглаж байгаа техник бүрийн тоогоор	ҮАЗ	ҮАЗ	2025 он	

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	хийхэд тохиромжтой байрлал нөхцөлөөр хангагдсан байх					
	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах	Уурхайн хүрээнд	Нийт ажилчдын тоогоор	500.0	5.0	2025 он
	Ажлын байранд эмнэлгийн анхны тусламж эмийн сан байрлуулах	ш	2	ҮАЗ	ҮАЗ	2025 он
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал- 600.0						

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын төрөл	Урьдчилан сэргийлэх буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Хатуу хог хаягдал	Хог хаягдлын цэгийн орчимд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хугацаатай хийж байх	удаа	6	200.0	200.0	Сар бүр	-Хог хаягдлын тухай хууль -Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага -Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага. MNS 5344:2011
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тухай нийт ажилчдад сургалт орох	Хүний тоогоор	Уурхайн нийт ажилчдад	ҮАЗ	ҮАЗ	2025 онд уурхайн үйл ажиллагаа эхлэх үед	
	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, тогтмол хугацаанд зөвшөөрөгдсөн цэгт хаях	удаа	-	600.0	600.0	2025 онд	
Шингэн хог хаягдал	Ахуйн бохир усыг цооногт хуримтлуулан бохир усны машинаар тогтмол соруулах	тн	-	ҮАЗ	ҮАЗ	2025 онд	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал 800.0 мян.төг							

ТАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь “Цагаан тугалганы ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор агаар, хөрс, гадаргын болон газрын доорх ус, ургамал, амьтаны нөхцөл байдалд ажиглалт явуулах, хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааны удирдамж болно.

2025 оны ОХШХ-ийг боловсруулахдаа 2022 онд Батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2023 онд хийгдсэн АУДИТ-ийн тайлан, дүгнэлт болон өмнөх онуудад хийсэн хяналт шинжилгээний үр дүнг үндэс болгов.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд, тэдгээрийн байршил, дээж авах хугацаа, давтамж, хяналт шинжилгээ хийх аргачлал, стандарт зэргийг төслийн БОННУ-ний тайланд тусгаснаар оруулав.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаарын чанар					
	— Хүхэрлэг хий (SO₂) — Азотын давхар исэл (NO₂) — PM_{2.5} тоосонцор — PM₁₀ тоосонцор	1. Уурхайн карьерийн Салхины чиглэлийн доор-1 цэг 47°38'04.57"N 107°57'11.07"E 2. Хяналтын цэг-1 47°38'22.50"N 107°56'41.68"E Нийт -2 цэг	Жилд 2 удаа /хавар, намарт тус бүр 1 удаа/	42.0	164.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885.2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
2.	Хөрсний чанар					
	Хөрсний бохирдлын үзүүлэлтүүд (хүнд металл): — Хар тугалга — кадми — зэс — никель — кобальт — мангани — хром — хүнцэл гэх мэт	1. Засварын газар 47°38'49.94"N 107°56'27.20"E 2. Баяжуулах хэсэг 47°38'13.95"N 107°57'11.21"E 3. Овоолго 47°38'08.76"N	Жилд 2 удаа (хавар, намарт тус бүр 1 удаа)	15.0	210.0	MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 3298:1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		107°57'27.41"E 4. Нөхөн сэргээлт хийсэн талбай 47°37'47.86"N 107°56'43.16"E 5. Хогийн цэг 6. Нүхэн жорлон 7. Хяналтын цэг 47°38'24.82"N 107°57'15.96"E Нийт 7 цэг				
3.	Хөрсний элэгдэл, эвдрэл					
	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд (Ялзмаг, урвалын орчин, карбонат, фосфор, кали, давсжилт, чулуужилт, хөрсний чийг, механик бүрэлдэхүүн гэх мэт)	1. Шимт хөрсний овоолго 47°38'01.28"N 107°57'05.92"E 2. Хотхон орчмоос 47°38'55.05"N 107°56'27.94"E 3. Баяжуулах хэсэг 47°38'13.95"N 107°57'11.21"E 4. Нөхөн сэргээлт хийсэн талбай 47°37'47.86"N 107°56'43.16"E 5. Хяналтын цэг 47°38'24.82"N 107°57'15.96"E Нийт 5 цэг	Жилд 2 удаа (хавар, намарт тус бүр 1 удаа)	15.0	150.0	MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 3298:1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4.	Усны чанар					

**Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай
“Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Усны ерөнхий химийн үзүүлэлт — Ундны усны мэдрэхүйн үзүүлэлт — Ундны усны байгалийн гаралтай химийн найрлагын үзүүлэлт — Ундны усны ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай бохирдлын химийн үзүүлэлт — Ундны усны хөдөө аж ахуйн үйл ажиллагааны гаралтай — Бичил амь судлалын аюулгүйн үзүүлэлт — Ууссан хүчилтөрөгч O ₂ — Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч BXX ₅ — Химийн хэрэгцээт хүчилтөрөгч XXX	1. Уурхайн ашиглалтанд байгаа худагаас-1 цэг 47°38'49.17"N 107°55'47.60"E 2. Хар хуст голоос- 1 цэг 47°37'28.71"N 107°56'36.56"E 3. Талбайн ойролцоох айлын ундахуйн худгаас- 2 цэг 47°39'02.24"N 107°58'26.29"E, 47°37'59.00"N 107°59'53.00"E 4. Газрын доорх усны хяналтын цэг -1 цэг 47°38'42.37"N 107°55'47.73"E Нийт 5 цэг	Жилд 2 удаа (хавар, намарт тус бүр 1 удаа)	46.0	460.0	
Ургамлын аймаг						
	Ургамлан нөмрөгийн тархалт, бүрхэц, нягтшил зэргийг тодорхойлох	1. Жил бүрийн биологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай 2. Төслийн талбайн ойр орчимд эрүүл нөлөөлөлд өртөөгүй талбай	Зуны улиралд жилд 1 удаа	200.0	200.0	Холбогдох аргачлалын дагуу
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал – 1,184.0 мян.төг						

ЗУРГАА. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов
	1	2	3	4
1	Эрдэнэ сумын Хушинга багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4-р улирал
2	Төв аймгийн Байгаль орчны газар	https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 - р сарын 1 дотор

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт “Авдрант” нэртэй газарт орших ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020997 дугаартай “Авдрантын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
3. Хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагаа
4. Барьцаа хөрөнгө байршуулсан баримт